



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 52

Есөнбулаг сум

“Бүтээлч Алтайчууд” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Бүтээлч Алтайчууд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний
өдрийн 52-р тогтоолын хавсралт




“БҮТЭЭЛЧ АЛТАЙЧУУД” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг үйлдвэрлэж буй мал аж ахуйн салбарт 300,0 гаруй мянган малчин ажиллаж, тээвэр, худалдаа, үйлчилгээ зэрэг эдийн засгийн томоохон салбаруудад 240.0 гаруй мянган иргэн хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь нийт ажиллагчдын 47,5 хувийг эзэлж байна.

Аймгийн 16.3 мянган өрхөд 56.7 мянган хүн суурьшин амьдарч байгаагийн 49,7 хувь буюу 28,2 мянга нь эрэгтэйчүүд, 50,3 хувь буюу 28,5 мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын дотроос хөдөлмөрийн насны 36.4 мянган хүн, үүнээс ажиллагсад 25,1 мянга, ажилгүй 2,4 мянга, ажилгүй иргэдийн 1368 буюу 56,9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 112 хоршоо байдгаас идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 74 хоршоо нь 4956 гишүүнтэй, 2.575.200.000 төгрөгийн үндсэн болон эргэлтийн хөрөнгөтэйгөөр идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бол ахуйн үйлчилгээний чиглэлээр 567 иргэн үйл ажиллагаа явуулж байна.



Үүний 393 иргэн буюу 69% нь эмэгтэйчүүд, 431 иргэн буюу 76% нь байнгын ажлын байртай. 136 иргэн буюу 24% нь түр ажлын байраар хангагдсан байна. Нийт ажиллагсдын ажлын байр нь 109 иргэн буюу 19% нь өөрийн, 291 иргэн буюу 51% нь түрээсийн 167 иргэн буюу 29% нь гэртээ үйл ажиллагаа явуулж байна. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор төрөөс 2006-2008, 2009-2011 онд

хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож эхэлсэн байна. Гэсэн хэдий ч зээлийн хүрэлцээ муу байна.

Дээрх иргэдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгосон зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан байдлыг сүүлийн 3 жилээр авч үзвэл:

№	Он	Санхүүгийн дэмжлэг		Зээл		Нийт дүн	
		Хүн	Хөр/сая.төг	Хүн	Хөр/сая.төг	Хүн	Хөр/сая.төг
1	2014	28	40.0	427	641.5	455	681.5
2	2015	101	135.0	245	585.7	346	720.7
3	2016	96	97.5	29	63.1	125	160.6
Нийт дүн		225	272.5	701	1290.3	926	1562.8

Гэсэн хэдий ч аймгийн хэмжээнд ажил хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэдийн тоо буурахгүй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн иргэдийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна.

Он	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэлтэй ажилгүйчүүд	812	847	1214	1237	981	786
Ажилгүй иргэдийн тоо	3605	2500	2895	2717	2403	2403

2016 онд ажил идэвхитэй хайж байгаа иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-34 насны иргэн 429 буюу 55 хувийг эзэлж байна. Үүнээс харахад 15-34 хүртэлх насны залуучууд бусдаасаа илүү ажил хөдөлмөр эрхлэх хүсэл тэмүүлэлтэй буйг харж болох юм.

Нийт ажил хайгчдын тоо /2017/		Үүнээс: 15-24 насны иргэдийн тоо		Үүнээс: 25-34 насны иргэдийн тоо	
Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм
786	435	141	77	288	162

Дээрх иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл бүрэн дунд боловсролтой иргэд 43,5 хувь буюу 341, Дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд 33,7 хувь буюу 265 байна. Үүнээс харахад бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 77 хувийг эзэлж байна.

Үүнээс дипломын болон бакалаврын дээд боловсролтой 211 иргэн байна. Энэ нь нийт ажилгүй иргэдийн 47,6 хувийг эзэлж байна

Насны бүлэг	Бүртгэлтэй ажилгүйчүүд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн анхан шат	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор
15-60	Нийт	5	28	42	341	70	35	263	2
	Эмэгтэй	4	16	23	178	38	26	159	1
15-34	Нийт	3	11	14	175	48	20	198	1
	Эмэгтэй	2	6	5	91	29	14	129	1

Иймд Алтай нутгийн хөгжлийн түүчээ болсон Баялаг бүтээгчдээ дэмжих, тэдний ажлын байрны тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа баялаг бүтээгчдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрны тогтвортой байдлыг хангах, шинээр ажлын байр бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

1. Орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг зохион байгуулж мэдээллийн сантай болно.
2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр шинээр бий болгох, тогтвортой байдлыг хадгална.
3. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний чанар хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг гаргаж, арга хэмжээнд хамруулах зорилтын хүрээнд:

4.1.1. Өрхийн болон бичил бизнес эрхлэгчдийн судалгааг салбар тус бүрээр нарийвчлан гаргаж мэдээллийн сан бүрдүүлэн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлно.

4.2.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулна.

4.1.3. Гадаад, дотоодын хандивлагч болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай холбон зуучлах үйлчилгэх үзүүлнэ.

4.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрны тогтвортой байдлыг хадгалах зорилтын хүрээнд:

4.2.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллийг хүргэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

4.2.2. Эдийн засгийн дэмжлэг шаардлагатай хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зээл, санхүүгийн дэмжлэг, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнд хамруулах замаар шинэ ажлын байр бий болгож ажлын байрны тогтвортой байдлыг хадгална.

4.2.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд үндэслэн шаардлагатай мэргэжилтэй ажилтаныг бэлтгэн нийлүүлнэ.

4.2.4. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангасан тохиолдолд ажил олгогчийг урамшуулах арга хэмжээнд хамруулах замаар ажлын байрны тогтвортой байдлыг хадгална.

4.2.5. Орон нутгийн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр иргэдэд хүргэх “Алтайд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг тогтвортой ажиллуулна.

4.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд ажил мэргэжлийн уралдааныг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж сурталчилан, тэднийг таниулах, алдаршуулах, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулна.

4.3.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дунд үзэсгэлэн худалдааг зохион байгуулж борлуулалтад нь дэмжлэг үзүүлэхээс гадна гадаадад үзэсгэлэн худалдаанд оролцоход хамтран ажиллана.

4.3.3. “Алтайд үйлдвэрлэв” төвийн бараа бүтээгдэхүүнийг онлайнаар худалдан борлуулах үйлчилгээг нэвтрүүлж борлуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах ажилд зарцуулах хөрөнгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.2. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хөтөлбөрт хамрагдсан иргэдийг ажлын байраар хангах гэрээ байгуулж, үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд байнга хяналт тавьж хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хугацаа

6.1. Хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжинэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1.1. Хөтөлбөрийн нийт санхүүжилт 628,2 сая төг

А. Орон нутгийн хөгжлийн сангаас хөтөлбөрт хуваарилсан хөрөнгө /23,0 сая төг/

Б. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орон нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал /590,2 сая төг/

В. Олон улсын байгууллага, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл /15,0 сая төг/

**Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах,
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл, Нийгмийн бодлогын хэлтэс байнгын хяналт тавина.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийж, тайлагнана.

Ес. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

9.1. Хөтөлбөрт хамрагдсан иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байна.

9.2. Хөтөлбөрт хамрагдсан өрхийн болон бичил бизнес эрхлэгчдийн орлого нэмэгдэж, шинэ ажлын байр бий болсон байна.